

2024 ОН I УЛИРЛЫН ТАЙЛАН

MSE:MLG

www.mlholding.mn



ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол улсын Тээврийн салбарын орлогын өсөлт

^ **+41%**

Монложистикс Групп Борлуулалтын орлогын өсөлт

^ **+28%**

Монложистикс Групп Тээвэрлэсэн ачааны өсөлт

^ **+19%**

Монложистикс Групп Экспортын ачаа тээврийн өсөлт

^ **+23%**

Монложистикс Групп Транзит ачаа тээврийн өсөлт

^ **+19%**

Монложистикс Групп гадаад улс доторх тээврийн өсөлт

^ **+130%**



Агуулга

- Эрхэм зорилго, алсын хараа
- Компанийн тухай
- Группийн түүхэн замнал
- Гүйцэтгэх Захирлын улирлын дүгнэлт
- Онцлох ажлууд – 2024
- Үйл ажиллагааны тайлан
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар



КОМПАНИЙН ТУХАЙ

Монложистикс Групп нь 2005 онд тээвэр зуучийн чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол өдгөө 1 толгой компани, 9 охин компани, 180 орчим ажилтан, 163 орны 800 гаруй харилцагч түнш, дотоодын 1500 гаруй үйлчлүүлэгчтэй Монгол улсын тээврийн салбарын тэргүүлэгч байгууллага болсон байна.

Монложистикс Групп нь Монгол Улсын иргэдийн өдөр тутам хэрэглэдэг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг импортлохоос эхлэн уул уурхайн түүхий эд бүтээгдэхүүнийг экспортлох, хөрш орнуудыг ачаа тээврээр холбох хүртэл импорт, экспорт, транзит, тракинг зэрэг тээвэр ложистикийн бүх төрлөөр олон улсын стандартад нийцсэн тээврийн цогц үйлчилгээг үзүүлсээр байна.

Монложистикс Холдинг ХК нь тээвэр ложистикийн цогц үйлчилгээ үзүүлэгч Группийн охин компаниудын бодлого, стратеги, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, тэдгээрт Хүний нөөц, Санхүү, Мэдээллийн технологи, Маркетинг, Стратеги, бизнес хөгжил, Ложистик гэсэн 6 чиглэлд менежментийн үйлчилгээ үзүүлдэг толгой компани юм.

Эрхэм зорилго

Дэлхий рүү тэмүүлэх үндэсний брэнд

Алсын хараа

Бид 2030 онд орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж, улмаар Монгол улсыг Ази Европыг холбосон ложистик төв болгоно.

Үнэт зүйлс

Өндөр чадвартай, мэргэжлийн хамт олон

Ажилтан бүр өөрийгөө олж нээн, авьяас чадвараа суралцах их хүсэл эрмэлзлээр хөгжүүлэн, оюун ухаан, хүч хөдөлмөрөө харамгүй зориулснаар өөртөө болон байгууллагад амжилт бүтэл дагуулж, бусдадаа үлгэрлэн манлайлах замаар дараагийн залгамж манлайлагч нарыг тасралтгүй төрүүлдэг байна.

Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл

Манай ажилтан бүр тасралтгүй суралцан, мэдлэг оюунаа тэлж, мэргэжлийн болон ерөнхий ур чадвараар цаг үетэйгээ үргэлж нийцэж, дэлхийн өнцөг булан бүрийн аль ч компанид тэнцэн ажиллах чадамж бүхий зорилго нэгт баг хамт олны нэг хэсэг байна.

Хариуцлага, сахилга бат

Манай байгууллагын ажилтан бүр өөрийн хариуцсан ажлыг хийхдээ хувийн өндөр сахилга баттай байж, ажилдаа өөриймсөг сэтгэлээр хандаж, Монгол улсын хууль тогтоомж, Группийн дотоод үйл ажиллагааны стандартыг ёс зүйтэй мөрдөж, ямар ч ажлыг туйлын хариуцлагатайгаар, чанар стандартын дагуу гүйцэтгэдэг байна.

Шударга, ил тод байдал

Манай бүх үйл ажиллагаа том жижиг, их багаас үл хамааран үнэнч шударга байх зарчим дээр суурилан бүхий л оролцогч талуудад шаардлагатай мэдээллийг нээлттэй ойлгомжтой, үнэн зөвөөр цаг ямагт хүргэж байх болно.

Инновацлаг багийн сэтгэлгээ

Манай хамт олон инновац, бүтээлч сэтгэлгээрээ багийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулан төгөлдөршүүлэхийн төлөө цаг үетэй хөл нийлүүлж, техник технологийн хөгжлийг хурдтай нэвтрүүлж, байнга шинийг санаачлагч багуудаас бүрдэнэ.

ГРУППИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ

Монголын Тээвэр зуучийн нэгдсэн холбоонд албан ёсны гишүүнээр элсэв.

2006 ОН



Монгол улсын Гаалийн ерөнхий газраас Гаалийн зуучлагчийн тусгай зөвшөөрлийг авав.

2010 ОН

Олон улсын тээвэр зуучийн нэгдсэн холбоонд албан ёсны гишүүнээр элсэв.

2014 ОН

Rebranding “Upgrade 10” төслийг амжилттай эхлүүлэв.

2016 ОН

2005 ОН

Монлогистикс Ворлдвайд ХХК анхны ууган компани байгуулагдав.



2009 ОН

Төмөр замын аюулгүй ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүлээн авав.



2011 ОН

Монголын гаалийн зуучлагчдын нэгдсэн холбооны гишүүнээр элсэв.



2015 ОН

ISO 9001:2008 Олон улсын чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэв.





Оюу толгой компанийн албан ёсны тээврийн компаниар шалгарав.



Монложистикс Холдинг ХХК
Толгой компани байгуулагдав.



Түүхий эдийн экспортын тээврийг эхлүүлж, Кaus Аустралис ХХК-ийг байгуулав.



Монложистикс Холдинг ХК
Do good HUB ТББ-ыг байгуулав.

2018 ОН

2020 ОН

2022 ОН

2023 ОН

2017 ОН

2019 ОН

2021 ОН

2023 ОН

Бүх тээврийг даатгалд хамруулах үйлчилгээг нэвтрүүлэв.

Монложистикс Транзит ХХК байгуулагдав.

Портфолио өргөжилт хийж, 3 охин компаниа байгуулав.

Монложистикс Холдинг ХХК Олон нийтэд нээлттэй компани болов.



monlogistics
GROUP



**ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ
ҮНДЭСНИЙ БРЭНД**



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН УЛИРЛЫН ДҮГНЭЛТ

Эрхэм хувьцаа эзэмшигч, уншигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэхийн зэрэгцээ Монложистикс группийн 2024 оны 1-р улирлын тайланг толилуулж байгаадаа таатай байна.

2024 оны 1-р улиралд Монгол улсын тээвэр ложистикийн салбарын болон Монложистикс группийн тээвэрлэсэн ачаа тээврийн хэмжээ тус бүр 19%-р өсөж, өмнөх жилийн өсөлтийн төлөв үргэлжилж байна. Манай Группийн экспортын ачаа тээвэр 22%-иар, транзит тээвэр 29%-иар мөн Монложистикс группийн ОХУ-д байрлах охин компанийн гадаад тээвэр 130%-иар тус тус өсөж, 2024 оныг бид бүхэн хүчтэйгээр эхлүүллээ. Үүний үр дүнд Группийн нийт орлого 51 тэрбумд хүрч, 2023 оны мөн үеэс 28%-иар өссөн юм.

Бид бүхэн 2024 онд Группийн хэмжээнд “Өсөлт” болон “Тогтвортой хөгжил” хоёр том зорилтын хүрээнд стратегийн ач холбогдол өндөр, урт хугацаанд бидний бизнест хүчтэй нөлөөтэй олон ажлыг төлөвлөгөөний дагуу амжилттай гүйцэтгэж байна. Эдгээр төслөөс дурдвал Группийн 6 компанид ISO 9001:2015 олон улсын чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, дижитал шилжилтийн хурдасгуур 3 төсөл болон богино, дунд, урт хугацааны бусад олон төслүүд дээр бүх түвшинд төвлөрч, эрч хүчтэйгээр ажиллаж байгааг та бүхэнд хуваалцаж байгаадаа баяртай байна.

Хүндэтгэсэн,

Г. ХИШИГБАТ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ОНЦЛОХ ТЭЭВЭР



Монложистикс Транзит ХХК
2024 оны 3-р сард УБТЗ-ын
үйлчлүүлэгч нарын зөвлөгөөнөөр
шилдэг транзит тээвэр зуучийн
шагналыг гардаж авлаа.




Монложистикс Тракинг ХХК
Монложистикс Тракинг ХХК 2024
оны 1-р сард Монос хүнс, Монос
косметикс компаниудын хамтарсан
Монгол улсаас Киргиз улс руу
экспортолж байгаа анхны тээврийг
амжилттай хийж гүйцэтгэлээ.



Монложистикс Ворлдвайд ХХК
Э.Жанцанхорол уран бүтээлчийн Mal-
ca-Amit Fine art бүтээлүүдийг тусгай
тээвэрлэлтийн горимоор амжилттай
хийж гүйцэтгэлээ.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



monlogistics
HOLDING

Монложистикс Холдинг ХК
олон нийтэд нээлттэй хувьцаат
компани болсноос хойших
анхны Үйл ажиллагааны жилийн
тайлангаа хувьцаа эзэмшигчдэдээ
танилцууллаа.

monlogistics
GROUP

Монложистикс Групп хүний
нөөцийн бодлогын хүрээнд шинээр
ажилд орсон ажилчдадаа 1 жилийн
ойн бонус урамшуулалтай боллоо.

monlogistics
HOLDING

Монложистикс Холдинг ХК
2023 оны жилийн эцсийн
цэвэр ашгаас “Ногдол ашиг”
хуваарилахаар боллоо.



monlogistics
HOLDING




Үйл ажиллагааны тайлан

- > Тээврийн салбарын нийт орлого
- > Монложистикс Группийн орлого
- > Тээврийн салбарын ачааны нийт хэмжээ
- > Монложистикс Группийн ачааны хэмжээ

ТЭЭВИЙН САЛБАРЫН ОРЛОГО

/ ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР /




2024 оны 1-р улирлын байдлаар тээврийн салбарын орлого 1.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 41%-иар өссөн байна.

* Салбарын орлогыг ЗТХЯамны 2024 оны 3-р сарын жин тонны мэдээлэл дээр үндэслэн бэлтгэсэн дотоод судалгаа болно.

МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН ОРЛОГО


/ ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР /



2024 оны 1-р улирлын байдлаар Монложистикс группийн орлого өмнөх оноос 28%-иар өсөж 51 тэрбум төгрөг болж өссөн байна.


* Салбарын орлогыг ЗТХЯамны 2024 оны 3-р сарын жин тонны мэдээлэл дээр үндэслэн бэлтгэсэн дотоод судалгаа болно.

ТЭЭВРИЙН САЛБАРЫН НИЙТ АЧААНЫ ХЭМЖЭЭ / МЯНГАН ТОННООР /



Тээврийн салбарын 2024 оны 1-р улирлын байдлаар нийт ачаа тээврийн эргэлийн хэмжээ 27.4 сая. тн хэмжээнд хүрч өмнөх мөн үетэй харьцуулахад 19%-иар өссөн байна.



МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН АЧААНЫ ХЭМЖЭЭ / МЯНГАН ТОННООР /



Монложистикс группийн ачаа тээврийн хэмжээ 257 мян.тн буюу өмнөх оны мөн үеэс 19.2%-иар өссөн үзүүлэлттэй байна.


ЭКСПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /





ИМПРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /



ТРАНЗИТ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /



ОЛОН УЛС ДАХ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /



monlogistics
HOLDING

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

2024 оны 4-р сарын 27

Компанийн нэр:

“Монложистикс Холдинг” ХК

Хурал болох байршил:

<https://hural.mlholding.mn>

Хурал болох огноо, цаг:


2024 оны 4-р сарын 27
Бямба гарагт, 14:00 цагт (UTC+8)

Хурал зохион байгуулах хэлбэр:

Зайнаас буюу цахим хэлбэрээр

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. ТУЗ-ийн 2024 оны цалингийн төсвийг батлах;



ХАЯГ

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Нью хоризонс оффис, 11 давхар, 1101 тоот

ХОЛБОО БАРИХ

+976 7701-5454

info@mlholding.mn

www.mlholding.mn